

ҮНӨӨДӨӨ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН | 2021

ГАРЧИГ

Товчилсон үгийн тайлбар	3
Нэгдүгээр бүлэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар	4
1.1. Бүтэц, зохион байгуулалт	4-4
1.2. Хүний нөөц:.....	5-5
1.3 Аудитын үр дүнгийн үзүүлэлт	6-7
Хоёрдугаар бүлэг. Санхүүгийн аудитын талаар	8
2.1 Санхүүгийн тайлангийн аудитын дүн	8-9
2.2 ОНТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит	10-10
2.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит.....	11
2.4 Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудит	11-11
2.5 Тусгай сангуудын санхүүгийн тайлангийн аудит	12
2.6 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн аудит	12
2.7 Аймгийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	13
2.8 Завсрын аудит.....	12
2.9 Төсвийн төсөлд өгсөн санал дүгнэлт.....	12
Гуравдугаар бүлэг. Гүйцэтгэлийн аудитын талаар	14-19
Дөрөвдүгээр бүлэг. Нийцлийн аудитын талаар	20
Тавдугаар бүлэг. ИТХ-ын хүсэлтээр болон өөрийн санаачилгаар хийсэн аудитын талаар	20-20
Аймгийн ИТХ-д үзүүлэх үйлчилгээний талаар:.....	20
Зургаадугаар бүлэг. Дотоод ажлын талаар:	21
6.1 Сургалтын талаар	21-22
6.2 Хамтын ажиллагааны талаар	23-26
6.3 Архив, албан хэрэг хөтлөлт:	27-27
6.4 Өргөдөл, гомдол шийдвэрлэлт:.....	29-28
6.5 Шагнал урамшуулал:	29
6.6 Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл түгээх үйл ажиллагаа:	30
6.7 Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	31-30
Долдугаар бүлэг. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар	32-32
Наймдугаар бүлэг. Дүгнэлт, санал	33
ҮАГ-т уламжлах санал, хүсэлт:.....	33

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
АГГ	Аудитын гуравдугаар газар
АНГ	Аудитын нэгдүгээр газар
АХГ	Аудитын хоёрдугаар газар
БХС	Байгаль хамгаалах сан
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ЗУГ	Захиргаа, удирдлагын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ММНБИ	Монголын Мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МХС	Мал хамгаалах сан
МТТ	Мэдээлэл технологийн төв
НА	Нийцлийн аудит
НАГ	Нийцлийн аудитын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЖАХ	Төрийн жинхэнэ албан хаагч
ТМЗ	Татварын мэргэшсэн зөвлөх
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБТГ	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар
ХХАГ	Харилцаа хамтын ажиллагааны газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШУДАГ	Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021.12.20

Чойр хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

1.1. Бүтэц, зохион байгуулалт

Төрийн аудитын байгууллагаас 2021 онд дэвшүүлсэн “Аудитыг цахимжуулж нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлж, төлөвшүүлэх” зорилтын хүрээнд Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар нь гол үйл ажиллагаагаа чиглүүлэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, МУЕА-ын 2021 оны А/28 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөөний дагуу аудитыг хийж гүйцэтгэхэд хүн хүч, цаг хугацаа, санхүүгийн нөөцөө боломжит хэмжээнд хуваарилан төлөвлөж ажиллалаа.

2021 онд хэрэгжүүлэх байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөөг МУЕА-ын орлогч болон тамгын дарга нараар батлуулж, нийт 4 зорилт, 63 арга хэмжээг төлөвлөснөөс төлөвлөсөн ажлаа 100% хийж гүйцэтгэлээ.

Байгууллагын 2021 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулснаар төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг ТЖАХ-ийн гүйцэтгэлийн

төлөвлөгөөнд тусгуулж, байгууллагын 5 ажилтны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, 2 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу ажиллагсдын төлөвлөгөөний биелэлтийг журамд зааснаар улирал тутам үнэлж, хагас, бүтэн жилээр дүгнэлээ.

2021 онд сар тутам хүний нөөцийн хөдөлгөөний мэдээ, ажлын явцын тайланг 14 хоног тутамд гарган хугацаанд нь ҮАГ-т цахимаар хүргүүлж, шаардлагатай асуудлыг тухай бүр шийдвэрлүүллээ.

Тайлант хугацаанд байгууллагын шуурхай хурлыг нийт 29 удаа зохион байгуулан давхардсан тоогоор 683 үүрэг даалгавар өгсөн ба хэрэгжилтийг 7, 14 хоног бүр тооцон ажиллалаа. Үүрэг даалгаврын хэрэгжилт 98.6 хувьтай байна. Хугацаа болоогүй 9 үүрэг байна. Албан хаагчид үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд ҮАГ-ын холбогдох газруудаас нийтдээ 139 удаагийн үүрэг чиглэл ирүүлснээс давхардсан тоогоор 250 удаагийн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэн тухай бүр хүргүүлсэн байна. Үүнд: Захиргаа удирдлагын газарт 155, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газарт 18, Аудитын нэгдүгээр газарт 15, Аудитын хоёрдугаар газарт 10, Аудитын гуравдугаар газарт 27, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт 7, Чанарын баталгаажуулалтын газарт 1, Харилцаа, хамтын ажиллагааны газарт 5, Мэдээлэл технологийн төвд 11 удаагийн үүрэг чиглэлийн биелэлтийг хүргүүлсэн байна.

ТАБ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Чанарын баталгаажуулалтын газраас 2021.09.28-наас 2021.10.04-ний хооронд аймаг дахь төрийн аудитын газрын



чанарын хяналтын тогтолцооны болон аудитын түвшинд чанарын баталгаажуулалт хийж, зөвлөмж өгч, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн.

ХШҮДАГ-аас 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний талаар хийсэн танилцуулга, уулзалтад хуваарийн дагуу оролцож, зөвлөгөө дэмжлэг авч ажилласан.

ҮАГ-ын Тамгын дарга, ЗУГ-аас зохион байгуулсан аймгуудын удирдах ажилтны шуурхай хуралдаанд хуваарийн дагуу 2021.11.08-ны өдөр байгууллагын 2021 оны эхний 10 сарын товч тайлан, мэдээллийг бэлтгэн танилцуулж, санал хүсэлтээ илэрхийллээ. Аймгуудын удирдах ажилтнуудын шуурхай хуралдаанд 2021.10.29-12.06-ны хооронд 6 удаа оролцож, мэдээлэл сонсож, зөвлөмж, чиглэл авч ажиллалаа.

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2021.06.15-ны А/13 дугаар тушаалаар Монгол Улсад Төрийн аудитын байгууллага үүссэний 100 жилийн ойг угтах болон тэмдэглэн өнгөрүүлэх, ойн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан зохион байгуулж ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилсон.


Тус төлөвлөгөөгөөр ҮАГ-ын хэмжээний арга хэмжээнд оролцоход бэлтгэх 3, орон нутгийн хэмжээнд зохион байгуулах 13, нийт 16 ажил хийхээр баталсан. 100 жилийн ой угтсан ажлын хүрээнд “100 жил-100 мод, арга хэмжээг зохион байгуулж, ТАБ-ын төгөл байгуулах зорилгоор аймгийн мод үржүүлгийн газрын талбайд газрыг хуваарилан авч, намар 50 мод тарьж, байгууллагын түүхэн замналын талаар ном хэвлүүлэх ажлын эхийг бэлтгэж, шаардлагатай зураг, материалыг бүрдүүлэх, спортын нэгдсэн арга хэмжээнд бэлтгэх зорилгоор аймгийн “Сансар хайрхан” спортын клубтэй хамтран ажиллах зэрэг ажлыг зохион байгууллаа.

1.2 Хүний нөөц:

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар нь тайлант хугацаанд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/19 дүгээр тушаалаар баталсан бүтэц, орон тооны дагуу үндсэн 7 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд: Дарга, тэргүүлэх аудитор-1, аудитын менежер-1, ахлах аудитор-2, аудитор-2, жолооч-1 байна. Мөн 1 гэрээт нягтлан бодогч-бичиг хэргийн ажилтантай байна.

Хүний нөөцийн 5 буюу 62.5% нь аудитын үйл ажиллагааг, 3 буюу 37.5% нь удирдлага болон дэмжих үйлчилгээний чиг үүргийг гүйцэтгэж байна.

Тус аймаг дахь Төрийн аудитын газрын хүний нөөцийн статистик тоо мэдээг дараах байдлаар харуулбал: Нийт 8 хүн ажиллаж байгаагаас 3 буюу 37.5% эрэгтэй, 5 буюу 62.5% эмэгтэй ажилтан байна. Насны бүтцийг авч үзвэл 25.0% нь 35 хүртэлх, 50% нь 35-40, 25.0% нь 40-өөс дээш насных байна.




Нийт ажиллагсдын 37.5% нь магистр, 50% нь бакалавр, 12.5% бүрэн дунд боловсролтой бол, 28.6% нь 1-5 жил, 28.6% нь 5-10 жил, 42.8% нь 10-аас дээш жил төрийн байгууллагад тогтвор суурьшилтай ажиллаж байна.

Боловсрол



Ажилласан жил



Мэргэжил



Нийт ажилчдын 7 нь нягтлан бодогч мэргэжилтэй бол тэдний 4 нь мэргэшсэн нягтлан бодогч, 3 нь Татварын мэргэшсэн зөвлөх байна.

1.3 Аудитын үр дүнгийн үзүүлэлт

Тус аймаг дахь Төрийн аудитын газар нь 2021 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 4 зорилтын хүрээнд нийт 63 арга хэмжээг хэрэгжүүлж, 316.6 сая төгрөгийг зарцуулан ажиллалаа.

2021 онд нийт 86 аудитыг гүйцэтгэж, бүх шатны төсөв захирагчийн төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланд 67 дүгнэлт гарган 69/495 хүн өдөр зарцуулж, 1187 илүү цаг ажиллалаа.

Тайлант хугацаанд 8 гүйцэтгэлийн аудитад 190 байгууллага, нэгжийн үйл ажиллагаа, тэдгээртэй холбоотой талуудын үйл ажиллагааг хамруулан аудитад нийт 8/334 хүн/өдөр зарцуулж, 468 илүү цаг ажиллалаа.



• Санхүүгийн тайлангийн аудитад 78 байгууллага хамрагдаж, аудитын тайлан, гэрчилгээг бүх шатны төсвийн захирагч нарт гардуулан өгсөн

• Нэгдсэн удирдамжаар 5, өөрийн санаачилгаар 2, аймгийн ИТХ-ын захиалгаар 1, нийт 8 аудитыг гүйцэтгэхээр төлөвлөснөөс аудитыг хугацаанд нь бүрэн гүйцэтгэлээ.

2021 онд хийж гүйцэтгэсэн аудитаар нийт 7,532.4 сая төгрөгийн 700 алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийн 51.0% буюу 3,841.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг аудитын явцад залруулан, 126.2 сая төгрөгийн зөрчилд 73 акт тогтоож, 1,927.7 сая төгрөгийн зөрчилд 115 албан шаардлага хүргүүлж, 1,563.1 сая төгрөгийн зөрчилд 182 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитын дүнд нийт илрүүлэлтийн 50.9 хувь буюу 3,834.9 сая төгрөгийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай, 21.2 хувь буюу 1,596.8 төгрөгийг улс, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй, 3.6 хувь буюу 274.0 сая төгрөгийг дотоод хяналт, хариуцлагатай холбоотой, 5.1 хувь буюу 383.7 сая төгрөгийг хууль, тогтоомжийн хэрэгжилттэй, 6.1 хувь буюу 457.9 сая төгрөгийг арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой, 11.2 хувь буюу 841.7 сая төгрөгийг худалдан авалттай холбоотой, 1.9 хувь буюу 143.5 сая төгрөгийг зориулалт бус зарцуулалт болон бусад асуудалтай холбоотой алдаа зөрчил эзэлж байна.

Тайлант хугацаанд орон нутгийн төсөвт 124.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, аудитад хамрагдсан байгууллагаас 2,644.8 сая төгрөгийн 132 үр өгөөжийг хүлээн зөвшөөрсөн нь төсвөөс авсан “нэг” төгрөгийн санхүүжилт тутамд 8.3 төгрөгийн үр өгөөж бий болгосон байна.

Төрийн аудитын байгууллагын 2021 оны аудитын үйл ажиллагаа, түүний үр дүнг товч тоон үзүүлэлтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Аудитын төрөл	Аудитын тоо	Илрүүлсэн алдаа, зөрчлийн дүн	Тогтоосон төлбөрийн актын дүн	Өгсөн албан шаардлагын дүн	Хүлээн зөвшөөрүүлсэн үр өгөөжийн дүн	Үүнээс: Залруулсан дүн	Өгсөн зөвлөмж /тоо/
Санхүүгийн аудит	78	6,044.7	124.0	695.4	1,362.9	3,841.4	133
Гүйцэтгэлийн аудит	8	1,487.8	2.2	1,232.3	552.5	-	49
Нийцлийн аудит	-	-	-	-	729.4	-	-
ДҮН	86	7,532.4	126.2	1,927.7	2,644.8	3,841.4	182

- ❖ **Төлбөрийн акт:** Тайлант хугацаанд 126.2 сая төгрөгийн 73 төлбөрийн акт тогтоосноос **98.5%** буюу 124.4 сая төгрөгийг барагдуулж, тайлант хугацааны эцэст 1.8 сая төгрөгийн 1 төлбөрийн актын үлдэгдэлтэй байна. Нийт барагдуулсан актаас 121.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 3.3 сая төгрөгийг байгууллагад буцаан олгуулсан байна. Өмнөх оноос дамжин хэрэгжсэн актын үлдэгдэл байхгүй.
- ❖ **Албан шаардлага:** Тайлант хугацаанд 1,927.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 115 албан шаардлага хүргүүлснээс 51.8% буюу 997.7 сая төгрөгийн 96 албан шаардлага, өмнөх оны үлдэгдлээс 119.9 сая төгрөгийн 6 албан шаардлага хэрэгжиж, тайлант хугацааны эцэст 929.9 сая төгрөгийн 19 албан шаардлага байна. Аудит хийсэн хугацаанаас шалтгаалж, хугацаа болоогүй 835.4 сая төгрөгийн 6 албан шаардлагын үлдэгдэл 89.8%-тай байна. Тайлант онд хугацаандаа хэрэгжсэн албан шаардлага **91.3%-тай** байна.
- ❖ **Зөвлөмж:** Гүйцэтгэсэн аудитын дүнд үндэслэн шалгагдагч этгээд болон хамрагдагч талуудад 182 зөвлөмж хүргүүлснээс хэрэгжилт 77.9 хувь буюу 141, өмнөх оноос шилжиж ирсэн зөвлөмж 91.3 хувь буюу 63 хэрэгжиж, тайлант хугацааны эцэст 46 зөвлөмжийн үлдэгдэлтэй байна. Аудит хийгдсэн

хугацаанаас шалтгаалан 56.5 хувь буюу 26 зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, 43.5 хувь буюу 20 зөвлөмж хугацаа хэтэрсэн байна. Тайлант онд хугацаандаа хэрэгжсэн зөвлөмж **90.4%-тай** байна.

- ❖ **Хариуцлага тооцуулах санал:** Тайлант хугацаанд гүйцэтгэсэн аудитын үр дүнгээр зөрчил гаргасан 7 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлснээс 6 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, хариу ирүүлэх хугацаа болоогүй 1 санал байна.


ХОЁРДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЛААР

2.1 Санхүүгийн тайлангийн аудитын дүн

Тус аймаг дахь Төрийн аудитын байгууллага нь хуулиар тодорхойлсон чиг үүргийнхээ дагуу улс, орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн 78 санхүүгийн тайланд аудит хийснээс 61 байгууллагад бие дааж аудитын дүгнэлт гаргаж, 6 байгууллагад итгэл үзүүлж, 11 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулжээ. Санхүүгийн тайлангийн аудитыг 100 хувь өөрсдийн нөөц бололцоог дайчлан хийж гүйцэтгэлээ.

Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 4, тусгай сан 11, төсвийн шууд захирагчийн 50, ОНӨААТҮГ-ын 6, нийт 73 байгууллагын санхүүгийн тайлан хамрагдав

Санхүүгийн тайлангийн аудитаар 61 байгууллагын санхүүгийн тайланд өгсөн санал дүгнэлтийн 54 буюу 90.0 хувийг зөрчилгүй, 3 буюу 5.0 хувийг хязгаарлалттай, 2 сөрөг санал дүгнэлт өгч, 1 тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.



Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 69/495 хүн/өдөр зарцуулж, 1,187 илүү цаг ажилласан бөгөөд нийт 6,044.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, илрүүлсэн зөрчлийн 63.6% буюу 3,841.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг аудитын явцад залруулсан байна.

Аудитаар залруулагдаагүй 124.0 сая төгрөгийн зөрчилд 70 төлбөрийн акт тогтоож, 695.4 сая төгрөгийн зөрчилд 103 албан шаардлага, 1,310.0 сая төгрөгийн зөрчилд 133 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 6 саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж ажиллалаа.

Тайлант хугацаанд тогтоосон 124.0 төгрөгийн төлбөрийн актын 122.2 сая төгрөг буюу 98.5%-ийг барагдуулж, 695.4 сая төгрөгийн албан шаардлагын 87.8%-ийг хэрэгжүүлсэн байна. Орон нутгийн төсөвт 118.9 сая төгрөгийг төвлөрүүлж, 3.3 сая төгрөгийг буцаан олгуулсан байна.

Тайлант хугацаанд өгсөн 133 зөвлөмжийн 123 зөвлөмж буюу 92.5%-ийг хэрэгжүүлж, 10 зөвлөмж хугацаа хэтэрсэн байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн актын үлдэгдэл байхгүй, 80.7 сая төгрөгийн 2 албан шаардлага бүрэн хэрэгжиж, 12 зөвлөмжийн үлдэгдлээс 10 зөвлөмжийн биелэлтийг хангуулсан байна.

Санхүүгийн аудитаар нийт 1,362.9 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн бүртгэснээр санхүүгийн тайлангийн аудитаар бий болсон Төрийн аудитын газрын зардлын “нэг” төгрөгт ногдох үр өгөөж 4.3 төгрөг болж байна. Санхүүгийн бус 29 үр өгөөжийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.


Санхүүгийн тайлангийн аудитад АДБОУС, АОУС, Үндэсний стандарт 6817:2020-ыг мөрдөж, УСНББОУС, СТОУС, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврыг шалгуур болгон ашиглаж, журам, гарын авлагын дагуу гүйцэтгэв. Аудитад СТАУС программыг ашиглаж, аудитын үе шат бүрд чанарын хяналтыг хэрэгжүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсөв захирагч нарт албан бичгээр хүргүүлж, танилцуулсан бөгөөд ҮАГ-ын Санхүүгийн аудитын газарт болон үйлчлүүлэгч байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.

Нийт илрүүлэлтийн 59.6%-ийг НББ, тайлагналтай холбоотой зөрчил эзэлж байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай болон сөрөг санал дүгнэлт авсан, дүгнэлт өгөхөөс татгалзсан 6 албан тушаалтанд хариуцлага тооцуулах тухай саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, бүрэн хэрэгжсэн байна.






Санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмж, түүний биелэлтийг өмнөх онтой харьцуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Санхүүгийн тайлангийн аудитаар 2021 онд 6,044.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 28.9%-иар буурсан үзүүлэлттэй байна. Санхүүгийн тайлангийн аудитын явцад залруулсан алдаа, зөрчлийг өмнөх онтой харьцуулахад 645.1 сая төгрөг буюу 14.1%-иар буурсан байна.

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага өмнөх оноос 14.5%, тогтоосон акт 77.6%-иар тус тус өссөн бол, зөвлөмжийн тоо 81-ээр тус тус буурсан байна.



2.2 ОНТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит

Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан хугацаанд гүйцэтгэж, ОНТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “зөрчилгүй” санал дүгнэлт өглөө.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т “аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлэх” гэж заасны дагуу ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төрийн аудитын байгууллагад хугацаанд нь ирүүлсэн болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 34 төсвийн байгууллага, 6 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 12 тусгайн сангийн, 3 төсвийн төвлөрүүлэн захирагчийн нийт 55 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 41 байгууллагад дүгнэлт гаргаж, 9 байгууллага түүвэрт хамрагдсан, 3 байгууллагад итгэл үзүүлсэн, 2

байгууллага аудитад хамрагдаагүй байна. Энэ тусгайлан төсөв батлагдаагүй Баянтал сумын МХС, БХС-гууд тул аудитад хамруулаагүй.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт 36, “Хязгаарлалттай” санал дүгнэлт 2 /аймгийн Боржигин чуулга, Баянтал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч/, “сөрөг” саналт дүгнэлт 2 /аймгийн “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ, Баянтал сумын Эрүүл мэндийн төв/, “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” 1 /Шивээговь сумын “Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ/ тус тус өгсөн байна.

Өөрчлөлттэй санал дүгнэлт авсан 3 байгууллагын удирдлагуудад хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж хэрэгжилтийг хангасан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 79.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 5.8 сая төгрөгийн алдааг залруулж, “Хязгаарлалттай” болон “Сөрөг” санал дүгнэлт авсан 2 төсвийн захирагчид хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 73.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгуулах 8 зөвлөмж өглөө. Үүнээс хариуцлага тооцох 2 албан шаардлага, 73.3 сая төгрөгийн 7 зөвлөмж хугацаандаа хэрэгжиж, 1 зөвлөмж хугацаа хэтэрсэн байна.

ТЭЗ-ийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт **4,393.2** сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн бөгөөд тайлант оны алдаа, зөрчлийн дүн өмнөх оноос 1,226.7 сая төгрөгөөр буюу 21.5 хувиар, зөвлөмжийн дүн 1,872.5 сая төгрөгөөр тус тус буурсан боловч актын дүн 13.1 сая, албан шаардлага 183.0 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

Тайлант хугацаанд 4 ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитыг төлөвлөсөн цаг хугацаанд нь гүйцэтгэж, тайланг баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Аудитад хамрагдсан 4 ТТЗ-ийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 3 байгууллагад “Зөрчилгүй”, 1 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт /Баянтал сумын ТТЗ/ өгсөн байна.

Аудитаар нийт 461.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 366.6 сая төгрөгийн алдааг залруулж, 1.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгуулах 2, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, 93.8 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 13 зөвлөмж өгсөн байна.

Үүнээс төлбөрийн акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн барагдуулсан бөгөөд 61.8 сая төгрөгийн 11 зөвлөмж хэрэгжиж, 32.0 сая төгрөгийн 2 зөвлөмжийн хугацаа хэтэрсэн байна.

2.4 Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант хугацаанд 54 ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитыг хийхээр төлөвлөсөн ба аудитыг хуулийн хугацаанд бүрэн гүйцэтгэж аудитын тайлан, дүгнэлтийг баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

Аудитад хамрагдсан 54 байгууллагаас 5 байгууллага түүвэрт хамрагдаж, 45 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллагад итгэмжлэл олголоо. Аудитад хамрагдсан 42 байгууллагад “Зөрчилгүй”, 2 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” санал дүгнэлт өгсөн байна.

Тус аудитаар нийт 3,720.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3,112.4 сая төгрөгийн алдааг залруулж, 115.9 сая төгрөгийн 64 төлбөрийн акт тогтоож, 283.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 76, хариуцлага тооцуулах 3, нийт 79 албан шаардлага хүргүүлж, 209.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 80 зөвлөмж өглөө.

Үүнээс 105.8 сая төгрөгийн 62 төлбөрийн акт, 280.9 сая төгрөгийн 74 албан шаардлага, 209.0 сая төгрөгийн 79 зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлж ажилласан ба 1.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 10.7 сая төгрөгийн 6 албан шаардлага, 1 зөвлөмжийн хугацаа хэтэрсэн байна.

2.5 Тусгай сангуудын санхүүгийн тайлангийн аудит

Тайлант хугацаанд гүйцэтгэхээр нийт 12 тусгай сангаас 1 тусгай сангийн тайланд итгэл үзүүлсэн ба 5 тусгай сангийн санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргах, 6 тусгай сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулахаар төлөвлөсөн бөгөөд санхүүгийн тайлангийн аудитыг төлөвлөсөн цаг хугацаанд нь гүйцэтгэж, тайланг баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

Аудитад хамрагдсан 11 тусгай сангаас 5 сангийн тайланд санал дүгнэлтийг гаргаж, 6 санд түүврийн аудитыг хийж дууслаа. Тусгай сангийн СТА-аар Зөрчилгүй-5 санал дүгнэлт өгсөн байна.

Тус аудитаар нийт 662.1 сая төгрөгийн 38 алдаа зөрчил илэрснээс 202.2 сая төгрөгийн 9 алдааг залруулж, 0.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 376.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 11 албан шаардлага хүргүүлж, 83.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 16 зөвлөмж өгсөн байна.

Үүнээс 0.5 сая төгрөгийн 2 төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 329.1 сая төгрөгийн 9 албан шаардлага, 67.2 сая төгрөгийн 15 зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлж ажилласан ба ба 47.1 сая төгрөгийн 2 албан шаардлага, 16.0 сая төгрөгийн 1 зөвлөмжийн хугацаа хэтэрсэн байна.

2.6 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн аудит

Аудитад нийт 6 орон нутгийн өмчит хуулийн этгээд хамрагдахаас 1 байгууллагад итгэл үзүүлсэн бөгөөд 4 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг төлөвлөсөн цаг хугацаанд нь гүйцэтгэж, тайланг баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

Аудитад хамрагдсан 4 ОНӨААН-ийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 3 байгууллагад “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн ба 1 байгууллагад нягтлан бодогч солигдсон шалтгаанаар СТА-д шаардлагатай баримт материалууд болон санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бүрэн гаргаж ирүүлээгүй, аудит хийх боломжгүй болсон тул санал дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Тус аудитаар нийт 282.9 сая төгрөгийн 54 алдаа зөрчил илэрснээс 154.4 сая төгрөгийн 22 алдааг залруулж, 14.5 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 27.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 7 албан шаардлага хүргүүлж, 12.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 10 зөвлөмж өгсөн ба 73.8 сая төгрөгийн алдааг залруулаагүй байна.

Үүнээс 14.5 сая төгрөгийн 4 төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 1.0 сая төгрөгийн 5 албан шаардлага, 2.3 сая төгрөгийн 7 зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлж ажилласан ба 26.6 сая төгрөгийн 2 албан шаардлага, 10.3 сая төгрөгийн 3 зөвлөмж хугацаа хэтэрсэн байна.

2.7 Аймгийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хуулийн хугацаанд аудит хийж, тайланг аймгийн ИТХ болон ТЕЗ-д хүргүүлээ. ТЕЗ-аас ирүүлсэн аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 20,554.8 сая төгрөгийн орлого, 18,712.5 сая төгрөгийн зарлагын гүйцэтгэлийг баталгаажуулав.

2020 онд орон нутгийн төсөвт нийт 20,554.8 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн ба ТЕЗ-ийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 20,554.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас төсвийн нийт зардлын гүйцэтгэл 18,712.5 сая төгрөг буюу 91.0 хувьтай байна. Тайлант онд нийт 1,842.3 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан ба үүний 1,118.4 сая төгрөг нь бодит бус хэмнэлт, 723.7 сая төгрөг нь бодит хэмнэлт байна.

Тайлант онд сангуудын болон төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан, хөрөнгө оруулалтын шинж чанартай ажлууд тухайн ондоо бүрэн хэрэгжээгүй зэргээс шалтгаалан бодит бус хэмнэлт үүссэн байна.

Аудитаар нийт 838.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх 8 зөвлөмж өгсөн ба 6 зөвлөмжийг хэрэгжүүлж, 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.8 Завсрын аудитын талаар:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын дагуу хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулж, сонгон шалгаруулалтад тэнцсэн “Эн ай ти эс баланс аудит” ХХК-тай санхүүгийн тайлангийн аудитын ажил гүйцэтгэх гэрээ байгуулах үйл ажиллагааг 2021.11.18-ны өдөр зохион байгууллаа.

МУЕА-ын 2021.09.06-ны өдрийн А/87 тоот тушаалаар санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэрийг баталсан ба уг тушаалаар гэрээгээр гүйцэтгүүлэх 20 байгууллага батлагдсан бөгөөд санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгүүлэхээр гурвалсан гэрээг байгууллаа.

2021-2022 онд гүйцэтгэх СТА-ын завсрын аудит хийх удирдамжийг баталж, удирдамжийн дагуу 53 байгууллагыг хамруулан гүйцэтгэж, аудитаар нийт 362.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлж, 46 зөрчилд 117.1 сая төгрөгийн алдааг залруулж, 71 зөрчилд 245.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах зөвлөмж өглөө.

2.9 Төсвийн төсөлд өгсөн санал дүгнэлт:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Засаг даргаас 2021.11.22-ны өдрийн А/341 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн орон нутгийн төсвийн 2022 оны төсвийн төсөлд дүгнэлт гарган аймгийн ИТХ-д 2021.12.01-ний өдрийн 273 дугаар албан бичгээр хүргүүлээ.

Төсвийн төсөлд төсвийн орлогыг нэмэгдүүлэх 288.2 сая, төсвийн зарлагыг бууруулах 1,004.5 сая, төсвийн үр ашгийг дээшлүүлэх 3,153.2 сая төгрөгийн санал, дүгнэлтийг хүргүүлээ.

Аймгийн ИТХ-ын 6 дугаар хуралдаан 2021.12.03-ны өдөр хуралдаж, орон нутгийн төсвийн 2022 төсвийн төслийг хэлэлцэн ТАБ-аас өгсөн дүгнэлтийн дагуу 231.4 сая төгрөгийн орлогыг нэмэгдүүлж, 126.0 сая төгрөгийн төсвийн зарлагыг бууруулан 1,975.3 сая төгрөгийн төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх саналыг хүлээн авч төсвийг хэлэлцэн баталж, хариуг ирүүлсэн байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЛААР

Төрийн аудитын байгууллагаас 2021 онд баталсан аудитын сэдэв, төлөвлөгөөний хүрээнд тайлант хугацаанд давхардсан тоогоор 190 байгууллагыг хамруулан 8 гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэсэн бөгөөд аудитад нийт 8/334 хүн/өдөр зарцуулж, 468 илүү цаг ажиллалаа.



Тайлант хугацаанд гүйцэтгэсэн нийт 8 аудитын 5 аудит буюу 62.5%-ийг УАГ-ын нэгдсэн удирдамжаар, 2 аудит буюу 25.0%-ыг өөрийн санаачилгаар, 1 аудит буюу 12.5%-ийг аймгийн ИТХ-ын хурлын захиалгаар тус тус хийж гүйцэтгэлээ.


Гүйцэтгэлийн аудитаар нийт 1,487.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 2.2 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 1,232.3 сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага, 253.0 сая төгрөгийн зөрчилд 49 зөвлөмж өгч, 0.3 сая төгрөгийн 2 алдааг залруулсан байна.

Гүйцэтгэлийн аудитаар тогтоосон 2.2 сая төгрөгийн төлбөрийн актыг 100.0% барагдуулж, 386.8 сая төгрөгийн 5 албан шаардлага, 160.6 сая төгрөгийн 18 зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан байна. Аудит хийсэн хугацаанаас шалтгаалан 835.4 сая төгрөгийн 6 албан шаардлага, 19.8 сая төгрөгийн 26 зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна. Хугацаа хэтэрсэн албан шаардлага 1, зөвлөмж 8 байна. Орон нутгийн төсөвт 2.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн 71.4 сая төгрөгийн 8 актаас 38.9 сая төгрөгийн 5 актыг барагдуулж, 39.2 сая төгрөгийн 6 албан шаардлагыг 100% хэрэгжүүлж, 57 зөвлөмжийн үлдэгдлээс 94.7% буюу 54 зөвлөмжийн биелэлтийг хангуулсан ба хугацаа хэтэрсэн 4 актын 32.5 сая төгрөг, 2 албан шаардлагын 10.0 сая төгрөг, 3 зөвлөмжийн үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын үр дүнд 552.5 сая төгрөгийн 9 санхүүгийн, 3 санхүүгийн бус үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн бүртгэснээр гүйцэтгэлийн тайлангийн аудитаар бий болсон Төрийн аудитын газрын зардлын “нэг” төгрөгт ногдох үр өгөөж 1.7 төгрөг болж байна.

Гүйцэтгэлийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн ангиллыг харуулбал:



Аудитаар илэрсэн нийт зөрчлийн 21.9%-ийг арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой зөрчил эзэлж байна.

Гүйцэтгэлийн аудитын үе шатны ажлыг хэрэгжүүлэх явцад ГАГ-аас ирүүлсэн судалгаа, мэдээллийг бүрэн гаргаж, мөн аудитын тайлан болон бусад холбогдох материалыг цахимаар болон цаасаар цаг хугацаанд нь хүргүүлж, ҮАГ-аас зохион байгуулсан цахим хурал, сургалтад бүрэн хамрагдлаа.

Тайлант хугацаанд дараах аудитуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар:



Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

Аудитыг нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд нэр зааж батлагдаагүй буюу салбарын ТЕЗ-д батлагдаж эрх шилжсэн 281.4 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс шилжих 8, шинээр хэрэгжих 11 төсөл арга хэмжээ батлагджээ. Дээрх 19 төсөл, арга хэмжээний 15 нь Говьсүмбэр аймгийн ТЕЗ-д эрх шилжиж хэрэгжсэн бол 4 арга хэмжээ эрх шилжээгүй хэрэгжсэн байна.

Аудитаар *“Төсөл, арга хэмжээний төлөвлөлт нэгдсэн бодлогын хүрээнд хийгдээгүй, он дамжин хэрэгжиж буй зарим ажлын гүйцэтгэл хангалтгүй, хүлээн авсан тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагад бүртгүүлээгүй, бүрэн хүчин чадлаар нь ашиглахгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна”* гэсэн дүгнэлт өгсөн.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар захиалагч буюу аймгийн ЗДТГ-т 4 зөвлөмж өглөө. Гүйцэтгэлийн аудитаар нийт 235.4 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах болон давтан гаргахгүй байх 4 зөвлөмж, 1.6 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 233.8 сая төгрөгийн 2 албан

шаардлага өглөө. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан байна.

Аудитын тайланг тэргүүлэх аудиторын 2021 оны А/08 дугаар тушаалаар баталгаажуулан аймгийн ИТХ болон ТЕЗ-д тус тус хүргүүлсэн.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 80, аудитын өртөг 8.7 сая төгрөг байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлд аудит хийх

Сонгуулийн зардлын гүйцэтгэлд хийх аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан баталсан.

Батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг 2021.08.16-09.01-ний хооронд гүйцэтгэлээ. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлд” хийсэн санхүүгийн аудитаар нийт 3.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 0.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 0.3 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 2.3 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитын тайланг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлж, байгууллагын цахим хаягт байршууллаа. Төлбөрийн актыг хугацаанд нь бүрэн барагдуулж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 40, аудитын өртөг 4.4 сая төгрөг



Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт

Аудитыг нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ. Аудитаар төсвийн шууд захирагч 60, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны дотоод аудитын чиг үүргийн хэрэгжилтийг шалгахад дотоод аудит хэрэгжүүлэх чиг үүргээ биелүүлж ажиллаагүй, төсвийн захирагч нар дотоод аудитын талаарх ойлголт дутмаг, дотоод аудиторууд нь дүрэмд заасан шалгуурыг бүрэн хангаагүй байна.

Аудитаар *“Дотоод аудитыг зохион байгуулах хууль эрх зүйн орчин бүрдээгүй, аудитын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтэц, хүний нөөц дутмаг, орон нутгийн хэмжээнд төрийн байгууллагуудад дотоод аудитын тогтолцоо байхгүй байна”* гэсэн дүгнэлтийг өглөө.

Аудитын дүнд үндэслэн аймгийн Засаг даргад 3, СХАА-нд 4, нийт 7 зөвлөмж, YAГ-т уламжлах 3 саналыг хүргүүлсэн. Аудит хийсэн хугацаанаас шалтгаалан зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 84.8, аудитын өртөг 9.2 сая төгрөг байна.

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо , төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн

Аудитыг УАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу гүйцэтгэсэн. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 1 зорилт, 4 арга хэмжээ төлөвлөн жил бүрийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлжээ.

Аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар хийж буй хяналт шалгалт тогтмолжсон боловч алдаа зөрчил давтагдсан
- Хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог зохицуулсан нэгдсэн бодлого байхгүй
- Хүнсний нөөцийг бүрдүүлэхдээ тооцоо судалгаанд үндэслээгүй, эрх зүйн зохицуулалтыг эрх бүхий байгууллагаас батлаагүй
- Орон нутагт хүнсний шим тэжээлийг шинжлэх лабораторигүй, урвалж бодис хангалттай бус, зориулалтын бус байранд үйл ажиллагаа явуулж байгаагаас магадлан итгэмжлэлд хамрагдаагүй.

Аудитын дүнд үндэслэн *“Орон нутагт хүнсний шим тэжээллэг байдлыг судлах лаборатори байхгүй байна” гэсэн дүгнэлтийг өглөө.*

Гүйцэтгэлийн аудитаар нийт 19.8 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илрүүлж, аймгийн Засаг даргад 3, холбогдох байгууллагуудад 5 зөвлөмж хүргүүлсэн. Аудит хийсэн хугацаанаас шалтгаалан зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 96, аудитын өртөг 10.5 сая төгрөг байна



Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө



Аудитыг УАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу гүйцэтгэсэн. Аймгийн Засаг даргын 2017 оны А/192 дугаар захирамжийн хавсралтаар Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх Говьсүмбэр аймгийн дэд хөтөлбөрийг 8 чиглэлээр 39 зорилтыг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Говьсүмбэр аймагт 2018-2020 онуудад 1 эм ханган нийлүүлэх байгууллага үйл ажиллагаа явуулсан байна. 2020 онд үйл ажиллагаа явуулсан 9 хувийн эмийн сан нь бүгд 2 дугаар зэрэглэлийн байна.

Аудитаар илэрсэн гол зөрчлүүдийг дурдвал:

- Ядуу, эмзэг бүлгийн хүн амд 2018-2020 онуудад төрөөс эмийн талаар дэмжлэг үзүүлээгүй байна.

- Мэргэжлийн хүн хүчний дутмаг байдал, барилга байгууламжийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалж эм зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөл хангалттай бүрдээгүй байна.
- Аймагт эмийн чиглэлийн боловсон хүчний нөөц дутагдалтайгаас орон тоо дутуу болон гэрээгээр ажиллаж байна.
- Эмийн зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа харилцан уялдаагүйгээс зөрчил дутагдал арилахгүй байна.
- Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлаагүй байна.

Аудитаар *“Ядуу, эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай эмийг ЭМДС-гаас санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй байна”* гэсэн дүгнэлтийг өглөө.

Аудитын үр дүнд үндэслэн аймгийн Засаг даргад 1, Эрүүл мэндийн газарт 8, нийт 9 зөвлөмж хүргүүлсэн. Аудит хийсэн хугацаанаас шалтгаалан зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 110, аудитын өртөг 12.0 сая төгрөг байна.

Өөрийн санаачилгаар:

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр 1,597.6 сая төгрөгийн 38 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан бөгөөд 1,487.1 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, 80.2 сая төгрөгийн ажлын гэрээ байгуулагдаагүй он дамжиж, 30.4 сая төгрөгийн гэрээний хэмнэлт үүссэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалт-6, шууд гэрээ-5, зөвлөх үйлчилгээ-1, харьцуулалтын аргаар 15 худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. Ажлын 2, зөвлөх үйлчилгээний 9, бараа үйлчилгээ худалдан авах 1, нийт 12 арга хэмжээ он дамжин хэрэгжсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зорилтот түвшнийг урьдчилан тооцоогүйгээс гүйцэтгэл болон хүрсэн үр дүнгийн талаар судалгаа хийгдээгүй, ашиглалтад хүлээн авсан хөрөнгө оруулалтын ажлыг ашиглагч байгууллагууд бүртгэж тайлагнаагүй, түүнд хяналт тавиагүй байна.

Аудитын дүн, нотлох зүйлд үндэслэн *“Бодлогын баримт бичигт нийцээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн, гүйцэтгэлийн хяналт, үр дүн хангалтгүй зөрчил дутагдал давтагдсаар байна”* гэсэн дүгнэлтийг өгсөн.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 303.3 сая төгрөгийн 11 зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах 150.0 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 153.2 сая төгрөгийн 9 зөвлөмж өглөө. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан байна.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 60, аудитын өртөг 15.0 сая төгрөг байна.





ОНӨААТҮГ-уудын худалдан авах ажиллагааны хуулийн хэрэгжилт

Аудитыг өөрийн санаачилгаар гүйцэтгэсэн бөгөөд аудитад Ус-Ду, Талын-Илч, Илчлэг-Шивээ, Тохижилт Сүмбэр, Цөм сүргийн үржлийн төв, Сум дундын ойн анги нийт 6 ОНӨААТҮГ-ын худалдан авах ажиллагааны 2019-2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн баримтуудыг хамрууллаа. Аудитаар илэрсэн гол зөрчлүүдийг дурдвал:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөлт хангалтгүйгээс шууд худалдан авалт хийсэн
- Захиалагч нь техникийн тодорхойлолтыг батлахдаа хуульд заасан тэгш шударга өрсөлдөх боломжийг

хязгаарласан

- Харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагаа зарласан тендер шалгаруулалт хуульд бүрэн нийцээгүй
- Гэрээнд алданги тооцохоор тусгаагүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй, хөрөнгө хүлээн авсан комиссын актыг бүрдүүлээгүй
- Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн “*Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг үр дүнтэй зохион байгуулаагүй, худалдан авах ажиллагааны гэрээг дүгнээгүй, хяналтыг хэрэгжүүлээгүй байна*” гэсэн дүгнэлтийг өгсөн.

Аудитаар нийт 835.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 5 албан шаардлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах 2 зөвлөмж өглөө. Аудит хийсэн хугацаанаас шалтгаалан зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 80, аудитын өртөг 8.7 сая төгрөг байна.

АИТХ-ын захиалгаар:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт

Тус аудитыг өөрийн санаачилгаар гүйцэтгэсэн бөгөөд аудитад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2019-2020 онд санхүүжүүлсэн 8 хөтөлбөрийн хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүнд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, хөтөлбөр, арга хэмжээг гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитаар илэрсэн гол зөрчлүүдийг дурдвал:



- Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн ажлын байр бий болоогүй, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2020 онд аймгийн хэмжээнд өмнөх оноос 6.2%-иар буурсан
- Хөтөлбөр тус бүрээр зорилтот түвшиндээ хүрч ажиллаагүй.
- Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнг тооцож, дүн шинжилгээ хийгээгүй

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн “*ХЭДС-аас хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний үр дүнгээр төлөвлөсөн ажлын байр нэмэгдээгүй, өмнөх онтой харьцуулахад хөдөлмөр эрхлэлтийн түвшин буурсан үзүүлэлттэй байна*” гэсэн дүгнэлтийг өгсөн.

Аудитаар нийт 90.6 сая төгрөгийн 10 алдаа зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах 13.0 сая төгрөгийн 2 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгсөн ба 3.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 40, аудитын өртөг 4.4 сая төгрөг байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЛААР

Тайлант хугацаанд бие даан гүйцэтгэхээр төлөвлөсөн нийцлийн аудит байхгүй бөгөөд Санхүүгийн тайлангийн аудитад нийцлийн аудитын хослуулан гүйцэтгэж, төсөв захирагчдын 2020 он санхүүгийн үйл ажиллагаанд Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийлээ. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах 41 албан шаардлага өгсөн байна. Албан шаардлагын хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн актын үлдэгдэл байхгүй, 390.5 сая төгрөгийн 8 албан шаардлагаас 343.1 сая төгрөгийн 7 албан шаардлагыг хэрэгжүүлж, 47.4 сая төгрөгийн 1 албан шаардлагын хугацаа хэтэрсэн, 453.6 сая төгрөгийн 41 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Өмнөх онд хийгдсэн нийцлийн аудитын үр дүнгээр 729.4 сая төгрөгийн 12 санхүүгийн, 5 санхүүгийн бус үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн бүртгэснээр гүйцэтгэлийн тайлангийн аудитаар бий болсон Төрийн аудитын газрын зардлын “нэг” төгрөгт ногдох үр өгөөж 2.3 төгрөг болж байна.

ТАВДУГААР БҮЛЭГ. ИТХ-ЫН ХҮСЭЛТЭЭР БОЛОН ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТЫН ТАЛААР

Аймгийн ИТХ-д үзүүлэх үйлчилгээний талаар:

Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан хугацаанд орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийж, тайланг аймгийн ИТХ-д хүргүүллээ.

Аймгийн ИТХ-д дэмжлэг үзүүлж, мэдээллээр хангах зорилгоор “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө”, Орон нутгийн төсвийн

2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг тус тус ажиллалаа.

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын хүсэлтээр “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт”, өөрийн санаачилгаар “Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө”, “ОНӨААТҮГ-уудын худалдан авах ажиллагааны хуулийн хэрэгжилт” сэдэвт гүйцэтгэлийн 3 аудит хийгдсэн байна.

2021 онд баталсан аудитын сэдэв, төлөвлөгөөний хүрээнд аймгийн ИТХ-ын болон өөрийн санаачилгаар гүйцэтгэсэн 3 гүйцэтгэлийн аудитад давхардсан тоогоор 127 байгууллагыг хамруулж, аудитад зарцуулсан хүн өдөр 4/120, аудитын өртөг 28.1 сая төгрөг, 124 илүү цаг зарцуулсан байна.

Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн Гүйцэтгэлийн аудитаар нийт 1,229.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 998.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 9 албан шаардлага өгч, алдааг засах, дахин гаргахгүй байх 19 зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ДОТООД АЖЛЫН ТАЛААР:

6.1 Сургалтын талаар

Төрийн аудитын байгууллагын мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөр, байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, суралцах нөхцөл бололцоог хангах зорилгоор албан хаагчдаас ерөнхий мэдлэгийн болон мэргэжлийн чиглэлээр ирүүлсэн 32 саналыг нэгтгэж, байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний төслийг хянаж, төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Тайлант хугацаанд зохион байгуулсан сургалтуудыг харуулбал:



ҮАГ-ын холбогдох газруудаас зохион байгуулсан 17 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 72 хүн, 14 удаагийн цахим хурал, уулзалт, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 48 хүн хамрагдсан байна. Үүнээс ЗУГ-аас 10, ХБТГ-аас 10, МТТ-өөс 4, АГГ-аас 3, АНГ-аас 2, ХХАГ-аас 2, ХШҮДАГ-аас 1 удаа тус тус зохион байгуулсан байна. Сургалтын тайлангаар дэлгэрэнгүй тайлагнасан.

Төрийн аудитын байгууллагын мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан “Хуулийн хэрэглээ болон төрийн аудитын суурь ойлголт, стандарт хэрэглээ” Е-хичээлд шинээр томилогдсон аудитор С.Батцэцэг, “Эдийн засгийн бодлогын шинжилгээ” сэдэвт цахим сургалтад аудиторууд бүрэн хамрагдаж, явцын болон эцсийн сорилын шалгалтыг амжилттай өглөө.

Тэргүүлэх аудитор ҮАГ-аас 4 дүгээр сарын 30-нд зохион байгуулсан “Удирдах ажилтны семинар”-т, 5 дугаар сарын 29-нд зохион байгуулсан “УИХ-ын болон Орон нутгийн сонгуультай холбоотой үүрэг чиглэл, арга зүйн зөвлөмж өгөх” сэдвийн хүрээнд явуулсан “Удирдах ажилтны семинар”-т, 7 дугаар сарын 09-нд зохион байгуулсан “ТАБ-ын удирдах ажилтнуудын зөвлөгөөн”, 10 дугаар сарын 14–ний өдрөөс 12 дугаар сарын 06-ны хооронд 7 хоног бүрийн Даваа гарагт ҮАГ-ын Тамгын дарга, ЗУГ-аас зохион байгуулсан Аймгийн удирдах ажилтнуудын шуурхай хуралд 5 удаа оролцон санал хүсэлтээ танилцуулан шийдвэрлүүлж, 11 дүгээр сарын 08-ны өдөр хуваарийн дагуу байгууллагын үйл ажиллагааны товч тайлан, мэдээллийг танилцуулсан.

Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу 10 сэдвээр 8 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 154 хүнийг хамруулсан байна. Дотоод сургалтын хүрээнд МУЕА-ын 2020 оны А/95, А/106 дугаар тушаалаар батлагдсан журмуудын танилцуулга мэдээллийг хийж, үйл ажиллагаандаа хэрхэн мөрдөж ажиллах, хэрэглэх талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Тайлант онд байгууллагын албан хаагчид өөрсдийн мэдлэг боловсролоо дээшлүүлэн аудитын менежер Г.Наранбаяр, ахлах аудитор Ц.Батсайхан нар ТМЗ-ийн эрх сунгах сургалтад онлайнаар хамрагдаж, 7 дугаар сард шалгалт өгч, эрхээ 3 жилээр сунгуулсан, аудитор Б.Анхтуяа МНБ-ийн эрх олгох шалгалтад 2 удаа хамрагдаж 1 хөнгөлөлт авсан ба нийт 4 хөнгөлөлттэй, МНБ болоход 1 шалгалт дутуу байна.

Сангийн яамнаас 10 дугаар сард зохион байгуулсан “Худалдан авах ажиллагааны АЗ” цахим сургалтад ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор Б.Анхтуяа нар хамрагдан шалгалтад орж эрхээ авсан.


Бусад байгууллагаас зохион байгуулсан 18 удаагийн сургалтад давхардсан тоогоор 94 албан хаагч хамрагдсан. Үүнд: зайнаас 1, цахимаар-9, танхимаар-4 удаа оролцож, хамрагдсан байна.


Тайлант хугацаанд зохион байгуулсан сургалтыг өмнөх онтой харьцуулбал: Диаграммаас харахад 2021 онд зохион байгуулсан сургалтын тоо болон хамрагдсан хүний тоо өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

6.2 Харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр:

Дэвшүүлсэн зорилтын хүрээнд харилцагч талуудын болон иргэдийн оролцоог хангах дэд төлөвлөгөөг батлан ажиллалаа.

Төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:





1.Аймгийн ИТХ:

Аймгийн ИТХ-д дэмжлэг үзүүлж, мэдээллээр хангах зорилгоор аудитын тайлангуудыг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. Үүнд:

- ТЕЗ-ийн 2020 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт
- Орон нутгийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан,дүгнэлт
- “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг
- Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө
- “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

Байгууллагын 2020 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээг нэгтгэн товхимол ном болгон хэвлүүлж хүргүүлээ.

АИТХ-аас аудитын сэдвийн санал авахаар албан бичиг хүргүүлэн хариуг бичгээр авсан бөгөөд 2022-2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийн саналыг аймгийн ИТХТ-ийн хуралд танилцуулан, 2022 онд гүйцэтгэх аудитын сэдвийг цахимаар иргэдээс санал авах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Аймгийн ИТХТ-ийн хуралд 2021.07.07-ны өдөр оролцож, байгууллагын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны товч тайлан, танилцуулга, мэдээлэл хийж, төрийн аудитын байгууллагаас 2022-2025 онд хийж гүйцэтгэх аудитын сэдвийн эрэмбэлсэн жагсаалтыг танилцуулж, санал хүсэлтийг сонслоо.

Аймгийн ИТХ-ын хуралдаанд оролцож, Орон нутгийн 2022 оны төсвийн төсөлд санал дүгнэлт гарган албан бичгээр хүргүүлж, төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа санал дүгнэлтийг хэрхэн хүлээн авч шийдвэрлэсэн талаарх хариуг авч, төсвийн орлого нэмэгдүүлэх, зарлага бууруулах, санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд хамтран ажиллалаа.

2.Гүйцэтгэх засаглал /Засаг дарга/

Байгууллагын 2020 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээг нэгтгэн товхимол ном болгон хэвлүүлж хүргүүлээ.

ТЕЗ-ийн 2020 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг гардуулж, цаашид анхаарах зүйлийн талаар зөвлөмж өгсөн.

УТХО, ОНХО, ХЭДС, ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, зөвлөмжийг хүргүүлсэн.

2021.05.24-нд аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд мэдээлэл хийж 45 байгууллагын удирдлага хамрагдлаа.

ТЕЗ-аас өргөн мэдүүлсэн Орон нутгийн 2022 оны төсвийн төсөлд санал дүгнэлт гарган, цаашид хэрэгжүүлэх аргам хэмжээ, зөвлөмжийг өгч, төсвийн төслийг хуульд нийцүүлэн боловсруулж төлөвлөх, төсвийн орлого нэмэгдүүлэх, зарлага бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд хамтран ажиллаж байна.

3. Шалгагдагч байгууллагууд

2021 оны 01 дүгээр сард төсвийн захирагч нарт Санхүүгийн тайлангийн аудит эхлэхтэй холбоотойгоор санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад анхаарах асуудал, тайланг хуулийн хугацаанд ирүүлэх талаарх мэдээлэл болон сургалтыг зохион байгуулж ажилласан ба сургалтад 22 байгууллагын дарга болон санхүүгийн ажилтнуудыг оролцуулж, 33 хүнийг хамруулсан.

Аудит эхлэх тухай бүр аудитын нээлтийг цахимаар болон танхимаар хийж, мэдээ, мэдээллийг хүргэж, чиглэл зөвлөмж өгч ажиллалаа.

Төрийн аудитын байгууллагын харилцагч талуудын болон иргэдийн оролцоог хангах стратеги төлөвлөгөөний хүрээнд ҮАГ-аас бэлтгэн гаргасан гарын авлага танилцуулгыг шалгагдагч байгууллагуудад тараан байгууллагын үйл ажиллагаагаа сурталчлан ажиллаж байна.



4. Авлигатай тэмцэх газар

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, авлигын эсрэг хууль болон төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 3 дугаар улирлын байдлаар 27 ажлыг хэрэгжүүлээд байна.

Алба хаагчдаар оны эхэнд ёс зүйн дүрмийг мөрдөх тухай мэдэгдэлд гарын үсэг зуруулж, хувийн хэрэгт хадгалсныг МУЕА-ын 2021 оны А/52 дугаар тушаалаар шинэчлэн баталсан ёс зүйн дүрмийн хавсралт маягтын дагуу шинэчлэн гарын үсэг зуруулж баталгаажуулан хувийн хэрэгт хадгаллаа.

Тайлант хугацаанд гүйцэтгэсэн аудит бүрд журмын дагуу АСМ-86, нөлөөллийн мэдүүлэг 94 хөтөлсөн. АТГ-аас зохион байгуулсан “Авлигын эсрэг үндэсний чуулга-2021” цахим чуулганд оролцлоо

Тайлант хугацаанд албан хаагчид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, ёс зүйн зөрчилгүй ажиллалаа.

4. ТББ, ИНБ

Аймгийн СТСХ, ММНБИ-ийн орон нутаг дахь салбар байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээний хүрээнд төсвийн байгууллагын нягтлан бодогч нарт НББ-ийн программ хангамжийг ашиглах, тайланг үнэн зөв гаргах чиглэлээр танхимын болон дадлага сургалтыг зохион байгуулан ажилласан.

Аймгийн ТАЗ-ийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд гишүүний хувьд оролцож, мэдээ, мэдээлэл авах, төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах чиглэлээр хамтран ажиллаж байна.

5. Хуулийн байгууллага

Аймгийн Прокурорын газартай хуульд заасан чиг үүргийн хүрээнд санамж бичиг байгуулан ажиллаж байна. /аудитын явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн бол, төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хугацаа хэтэрсэн акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах г.м/

Аудитын үйл ажиллагаатай холбоотой хууль хяналтын байгууллагад шилжүүлэх шаардлагатай асуудал гараагүй байна.

Тайлант хугацаанд шалгагдагч байгууллага буюу аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд МУЕА-т гомдол гаргасан боловч гомдлыг хүлээн аваагүй актыг хэвээр үлдээсэн тул аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж, анхан шатны шүүхийн шийдвэрээр актыг хүчингүй болгосныг эс хүлээн зөвшөөрч, давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаснаар шүүх хуралдаан 2021.12.15-ны өдөр болж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, актыг хэвээр үлдээлээ.

6. Үндэсний аудитын газар

Мэдээлэл технологийн төвтэй аудитыг цахимжуулах жилийн хүрээнд 2021 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд дараах байдлаар хамтран ажиллалаа. Үүнд:

1. Хүний нөөцийн систем (hr.audit.mn)-д албан хаагчдын мэдээллийг бүрэн шивж оруулсан.
2. Шилэн дансны хяналтын систем (local.audit.mn)-д шалгагдагч асуудлын бүртгэлийг оруулсан.
3. Статистик мэдээний бүртгэлийн программ (local.audit.mn)-д 2020, 2021 оны мэдээг бүрэн шивсэн.
4. Санхүүгийн тайлангийн программ (fas.audit.mn)-г завсрын аудитад ашигласан.
5. Цахим сургалтын программ (surgalt.audit.mn)-д тавигдсан сургалтын хөтөлбөр, хичээлийг судалсан.
6. Аудитын 14 хоногийн явцын мэдээг Аудитын нэгдсэн удирдлага, бүртгэл мэдээллийн систем (Data.audit.mn)-д тухай бүр оруулж хэвшсэн.
7. Гүйцэтгэлийн аудитад Microsoft teams ашиглан цахимаар мэдээлэл солилцож хэвшсэн.
8. Zoom программыг ашиглан 2021 онд хийсэн 7 аудитын нээлт болон явцын уулзалтыг цахимаар зохион байгуулсан.
9. Иргэд олон нийтээс авах санал асуулгыг Google form ашиглан 100% цахимаар авсан.
10. Цахимжуулалтын жилийн хүрээнд ҮАГ-аас хуваарилсан 20.0 сая төгрөгөөр аудит хийж гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авалтыг цаг алдалгүй хийж материаллаг бааз суурийг сайжруулсан.

Чанарын баталгаажуулалтын газар:

Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Чанарын баталгаажуулалтын газраас 2021 оны 09 дүгээр сарын 28-наас 10 дугаар сарын 04-ний хооронд “Аймаг дахь төрийн аудитын газрын чанарын удирдлагын тогтолцооны болон аудитын түвшинд чанарын баталгаажуулалт”-ыг хийсэн ба тус хугацаанд аудиторуудад Гүйцэтгэлийн аудит, Нийцлийн аудит, Санхүүгийн тайлангийн аудит хийхэд анхаарах асуудлын талаар зөвлөгөө, мэдээллийг 2 цагийн хугацаатай явуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн.



Иргэдийн оролцоог хангах чиглэлээр:

2022 онд гүйцэтгэх аудитын сэдвийг цахимаар иргэдээс санал авах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Аудитыг хийж гүйцэтгэсэн тухай бүр аудитын тайланг, мөн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээллийг цахим хуудсанд нээлттэй, ил тод мэдээлж байна.



Мэдээллийн ил, тод байдал:

Байгууллагын үйл ажиллагааны болон аудитын талаарх цаг үеийн шинжтэй 23 мэдээлэл, тайлант хугацаанд хийгдсэн СТА-ын 61 тайлан, дүгнэлт, ГА-ын 4 тайланг олон нийтэд хүргэх зорилгоор www.audit.mn цахим хуудсанд тухай бүр байршуулсан.

6.3 Архив, албан хэрэг хөтлөлт:

2021 онд байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, заавар, стандартын хүрээнд зохион байгуулж, төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар, дүрэм, журам, стандартын шаардлага хангасан баримт бичиг боловсруулж ирсэн, явсан албан бичгийг тухай бүрд нь бүртгэж, холбогдох албан тушаалтанд цохолт хийн үүрэгжүүлж, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллалаа.



Дарга, тэргүүлэх аудиторын тушаал болон аудитын явцад илэрсэн зөрчлийн акт, албан шаардлагын үндэслэл болгосон хууль, тогтоомж, шийдвэрийн заалтуудыг тухай бүр хянаж хууль эрх зүйн зөрчилгүй гаргууллаа.

“Тэргүүлэх аудиторын тушаал, бусад шийдвэр, аудитын явцад илэрсэн зөрчилд тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг хууль эрх зүйн зөрчилгүй гаргууллаа. СТА-ын гэрчилгээ, төлбөрийн акт, албан шаардлагыг тус бүр 3 хувь хэвлэн 1 хувийг тусад нь архивлаж хэвшсэн.

Байгууллагын БНШК-ыг шинэчлэн баталж комиссын ажиллах дүрмийг шинэчлэн баталж, 2021 оны ХХНЖ-ыг боловсруулан баримт бичиг нягтлан шалгах комиссыг 2 удаа хуралдуулан 2021 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, 2021 оны архивын баримтын тооллогын дүнг хянан хэлэлцсэн. Аймгийн Архивын тасгаас ирүүлсэн албан бичгийн дагуу байгууллагын архивын хадгаламжийн нэгжийн мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

Байгууллагын ХХНЖ-ын дагуу нийт 184 баримтыг хүлээн авч архивын бүртгэлд бүртгэн товъёогжуулсан ба архивын нэгжийг он цагийн дарааллаар цэгцлэн хадгалж байна.

Байгууллагын архивт 2017-2021 оны байнга хадгалах 397, 70 жил хадгалах 18, түр хадгалах 238, нийт 653 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

АЗДТГ-ын Архивын тасгаас ирүүлсэн албан бичгийн дагуу цахим баримтын бүртгэлийн ажилд батлагдсан хуваарийн дагуу 10 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд аймгийн Төрийн архивд ажиллаж, тус архивд хадгалагдаж буй өөрийн байгууллагын хадгаламжийн нэгжийг цахимжуулах ажлыг гүйцэтгэсэн. Төрийн хянан шалгах хорооны 1995-2002 оны 76, Төрийн аудитын газрын 2003-2016 оны 465 баримтыг AMS программд шивж оруулан цэгцлэх товъёогжуулах ажлыг хийж, 2003-2016 оны “А” тушаалуудыг сканердаж фотошопоор сэргээн засан цахимд орууллаа.

Лавлагаа олгох бүртгэлийг журмын дагуу хөтөлж хэвшсэн ба журмын дагуу байгууллагын архиваас Говьсүмбэр аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2018 оны баримтаар 36 хуудас материалыг хуулбарлан өгсөн.

Албан хэрэгцээнд бүртгэлээр 2017-2020 оны 76 баримтыг давхардсан тоогоор 22 албан хаагчид өгч ашиглуулан, буцаан хүлээн авсан байна.

2021.09.28-наас 2021.10.04-ний хооронд байгууллагын архивд хадгалагдаж буй баримтуудаас 2018, 2019, 2020, 2021 оны 28 хавтас баримтыг УАГ-ын ЧБГ-аас ирсэн Чанарын баталгаажуулалтын шалгалтын ажлын хэсэгт ашиглуулахаар бүртгэлээр өгч, архивд буцаан хүлээн авсан.

Тайлант хугацаанд Тэргүүлэх аудиторын “А” тушаал 29, “Б” тушаал 18 гарсан ба СТА-ын 60 гэрчилгээ, 74 төлбөрийн акт, 115 албан шаардлага хэвлэгдсэн байна.

Дарга, Тэргүүлэх аудиторын 2021 оны “А” тушаалын хэрэгжилтийг хагас болон жилийн эцсийн байдлаар гаргуулан, хяналт хийлээ. Тушаалын хэрэгжилт 99.2%-тай, хэрэгжилтийг тооцох болоогүй аудитын тайлан баталгаажуулсан 5 тушаал байна.

2021 онд тус байгууллагад УАГ-аас цахим болон шуурхай мессежээр ирсэн 246, бусад байгууллагаас ирсэн 567, нийт 813 бичгийг хүлээн авч бүртгэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан. Хариутай 156 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн.

Тайлант хугацаанд тус газар 286 албан бичиг явуулснаас хариу ирүүлэх 154 бичгээс 146 бичгийн хариуг хугацаанд нь авч, хариу ирүүлэх хугацаа болоогүй 8 бичигт хяналт тавин ажиллаж байна.

Явуулсан, ирсэн бичгийн бүртгэлийг байнга хөтлөн, сканердан Able программд бүрэн оруулсан. Албан хэрэг хөтлөлтийн эргэлтийн мэдээг сар бүрийн 05-ны дотор гаргаж удирдлагад мэдээлж хэвшсэн байна. Албан хэрэг хөтлөлтийн стандарт, МУЕА-ын 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/03 дугаар тушаалаар батлагдсан хэвлэмэл хуудасны индексийн дагуу тусгай дугаарлагчаар дугаарлан хэвлэмэл хуудсыг үнэн зөв дугаарлуулж, ашиглалтад хяналт тавьж ажиллалаа.

6.4 Өргөдөл, гомдол шийдвэрлэлт, нийгмийн асуудал:

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг МУЗГ-ын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын дагуу сар бүр гаргуулан хяналт тавьж ажиллалаа.

Тайлант хугацаанд иргэн болон албан хаагчдаас ирүүлсэн нийт 10 өргөдлийг хүлээн авч бүртгэн хуулийн хугацаанд шийдвэрлэлээ. Бүртгэж хүлээн авсан өргөдлөөс 3 өргөдлийг шийдвэрлүүлэхээр ҮАГ-т хүргүүлэн шийдвэрлүүлсэн. Тус газар иргэдээс ирүүлсэн 3 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.

2021 онд Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт албан хаагчид хамрагдаагүй, байгууллагын төсөвт зардал батлагдаагүй байна. Тэргүүлэх аудитораас МУЕА-т тэтгэмж, дэмжлэг хүссэн өргөдөл гаргасан боловч тайлант онд шийдвэрлэгдээгүй байна.

ТАБ-ын хөдөлмөрийн дотоод журмын дагуу байгууллагын албан хаагчдаас ирүүлсэн өргөдлийг төсөв, санхүүгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан ҮАГ-т уламжлан хүргүүлж төсвийг шийдвэрлүүлэн 3 албан хаагчид нийт 2.0 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг олголоо.

Байгууллагын 3 өндөр настанд Ахмадын сангийн журамд заасны дагуу сар шинийн баяр болон ахмадын баяраар 0.6 сая, эмчилгээний зардалд 1.5 сая, түлээ нүүрсний хөнгөлөлтөд 0.3 сая, нийт 2.4 сая төгрөгийн дэмжлэг тусламжийг олгосон байна.

6.5 Шагнал урамшуулал:

Төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан Төрийн аудитын байгууллагын “Хүндэт жуух бичиг”-ээр шагнуулахаар аудитор Б.Анхтуяаг шагналд тодорхойлон холбогдох материалыг ҮАГ-т хүргүүлж, шагнууллаа.





Тус газрын дарга, тэргүүлэх аудитораар ажиллаж байсан Ш.Ичинхорлоо нь 2021 онд төрийн дээд шагнал “Монгол Улсын Гавьяат эдийг засагч” цол тэмдгээр шагнагдсан тул хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн Говьсүмбэр аймгийн ИТХ-ын “Говьсүмбэрийн төлөө” медалиар шагнууллаа.

Аймгийн удирдах байгууллагаар дамжуулан харьяалалтай өндөр настан Д.Санжидмааг Төрийн дээд “Алтангадас” одон, А.Мөнхцэцэгийг “Хөдөлмөрийн хүндэт” медаль"-иар тус тус шагнуулахаар холбогдох материалыг бүрдүүлэн хүргүүлснээс өндөр настан Д.Санжидмааг Монгол Улсад Бүртгэл, санхүү, эдийн засгийн алба үүсч хөгжсөний 110 жилийн ойг тохиолдуулан төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнууллаа. Өндөр настныг хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.



6.6 Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл түгээх үйл ажиллагаа:



2021 онд байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байдал, аудитын үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг олон нийтэд хүргэх зорилгоор www.audit.mn цахим хуудсанд байгууллагын болон аудитын үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг тухай бүр байршуулсан байна.

Тайлант хугацаанд хийгдсэн аудитын тайланг тухай бүр цахим хуудсанд байршуулан ажилласан ба нийт 65 тайланг байршуулснаас Санхүүгийн аудитын тайлан 61, ГА-ын тайлан 4 байна. 2021 оны сүүлийн хагас жилд нэгдсэн удирдамжаар хийгдсэн 3 аудитын тайланг ҮАГ-т нэгтгэн эцэслэж баталгаажуулаагүйтэй холбоотойгоор цахим хуудсанд байршуулаагүй байна.

Байгууллагын цахим хуудсаар дамжуулан үйл ажиллагааны мэдээг олон нийтэд түгээж хэвшсэн бөгөөд цаг үеийн шинжтэй 23 мэдээллийг байршуулсан байна. Дотоод үйл ажиллагаанд ашиглах мэдээллийн самбарыг байнга ажиллуулахаас гадна дэлгэцэд аудиттай холбоотой мэдээллийг тогтмол байршуулж байна.

ҮАГ-аас цахимаар болон албан бичгээр 246 албан бичиг ирсэн, хариу хүргүүлэх 156 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Шилэн дансны улирлын тайланг хугацаанд нь илгээсэн ба 4 дүгээр улирлын байдлаар хуулийн хугацаанд оруулах 149 мэдээллийг сар бүр хугацаанд нь бүрэн байршуулж ажилласан. Хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор аймгийн ИТХ-ын даргад 5 удаа, аймгийн Засаг даргад 6 удаа шаардлагатай аудитын тайлангуудыг тухай бүр хүргүүлэн ажиллалаа.

6.7 Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх



Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, авлигын эсрэг хууль болон төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төлөвлөгөөний дагуу 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор 39 ажлыг гүйцэтгэж, төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай байна. Төрийн аудитын байгууллагын ажилтан албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигын эсрэг хуулийн дагуу хугацаанд нь хүлээн авч, 6 албан хаагчийн ХАСХОМ-ийг хянан, баталгааны хуудсыг баталгаажууллаа. Баталгааны хуудсыг хувийн хэрэгт хадгалсан. 2021 онд 1 албан хаагчийн ХАСУМ болон шинээр томилогдон ажилласны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд гаргуулан авч баталгаажуулсан.

Төрийн болон албаны нууцтай холбоотойгоор ажилтнуудын хувийн дугаар бүхий лацыг тогтмол ашиглаж хэвшсэн байна.

Алба хаагчдаар оны эхэнд ёс зүйн дүрмийг мөрдөх тухай мэдэгдэлд гарын үсэг зуруулж, хувийн хэрэгт хадгалсныг МУЕА-ын 2021 оны А/52 дугаар тушаалаар шинэчлэн баталсан ёс зүйн дүрмийн хавсралт маягтын дагуу шинэчлэн гарын үсэг зуруулж баталгаажуулан хувийн хэрэгт хадгаллаа.

Тайлант хугацаанд аудит хийх тухай бүр ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдлийг гаргасан ба нийт 100 мэдэгдэл гаргаж, албан хаагчид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ёс зүйн зөрчилгүй ажиллалаа. Тайлант хугацаанд гүйцэтгэсэн аудит бүрд журмын дагуу нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн бөгөөд нийт 97 нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн байна.

Аудитын үйл ажиллагааг сонирхлын зөрчлөөс ангид хэрэгжүүлсэн ба ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн ажилтан байхгүй байна.

“Төрийн болон албаны нууц хамгаалалт, бүртгэл хөтлөлт, архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулж ажилласан ба албан хаагчдаар нууцын баталгаа гаргуулж хадгалсан, мөн Төрийн аудитын байгууллагын төрийн болон албаны нууц хамгаалах дотоод журмын хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Тагнуулын ерөнхий газрын Говьсүмбэр аймаг дахь хэлтэст Төрийн болон албан нууцын тухай хуулийн дагуу 2020 оны тайлан, байгууллагын нууц хадгалалт, хамгаалалтын талаарх холбогдох мэдээллийг тус тус гаргаж хүргүүлсэн.

Говьсүмбэр аймаг дахь Тагнуулын хэлтсээс ирүүлсэн албан бичгийн дагуу “Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, шаардлага”, “Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын үйл ажиллагааны дүрэм” стандартуудын асуумжийг Мэдээлэл технологийн төвөөс заавар зөвлөгөө авч үнэн зөв бөглөж хүргүүллээ.

Говьсүмбэр аймаг дахь Тагнуулын хэлтсээс зохион байгуулж буй төрийн болон албаны нууцын тухай хууль журмын хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт шалгалтад хамрагдаж, өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг гарган хүргүүлсэн.

ТЕГ-аас зохион байгуулсан “Төрийн болон албаны нууцын тухай хууль”ийн мэдлэг олгох 1 өдрийн цахим сургалтад бүх алба хаагчид бүрэн хамрагдлаа.

ДОЛДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР

Байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдсан бөгөөд 2021 онд 317.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 316.6 сая төгрөгийг зарцуулж, нийт 1.0 сая төгрөгийн хэмнэлттэй, өглөг, авлагагүй ажиллалаа. Төсвийн хуваарьт 4 удаа өөрчлөлт орж, төсөв 20.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд зарцуулсан нийт зардлын 87.5% буюу 276.9 сая төгрөгийг цалин, НДШ зардал, 11.4% буюу 36.1 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд 1.1% буюу 3.6 сая төгрөг нь тэтгэмж урамшууллын зардалд зарцуулсан байна.

Төсвийн тухай хуульд заасны дагуу байгууллагын санхүүгийн тайланг НББ-ийн “Юникус” программаар улирал тутам бэлтгэн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж, ҮАГ-т хүргүүлж, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллалаа.

ҮАГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу байгууллагын 2022 оны төсөв, 2023-2025 оны төсвийн хязгаарын саналыг боловсруулж, төсвийн төслийн санал бэлтгэн хугацаанд нь Захиргаа, удирдлагын газарт 2021.05.20-ны өдрийн 153 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

СХОХ-ээс өгсөн чиглэлийн дагуу байгууллагын 2022 оны төсвийн төслийг 2021.07.26-ны өдөр Юникос программд шивж оруулсан. Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн санхүү, төсөвтэй холбоотой мэдээ, судалгаа, мэдээллийг цаг тухайд нь гаргаж, хүргүүлэн ажилласан.

Хуулийн дагуу ҮАГ-ын гэрээний хүрээнд “Мишээл-Од Аудит” ХХК-иар 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийлгэж, баталгаажуулан “Зөрчилгүй” санал дүгнэлт авлаа.

Байгууллагын санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хугацаанд улирал бүр бэлтгэн гаргаж, ҮАГ-ын ЗУГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст тухай бүр албан бичгээр хүргүүлэн ажиллалаа.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ны дотор ҮАГ-т, Нийгмийн даатгалын тайланг сар бүр, татварын тайланг улирал бүр гарган, хуулийн хугацаанд тайлагнаж байна. Тайлант хугацаанд төсвийн гүйцэтгэлийн мэдээг 12, санхүүгийн тайланг 4 удаа, Нийгмийн даатгалын тайланг 12 удаа, татварын тайланг 4 удаа тус тус бэлтгэн гаргасан бөгөөд тайлант хугацааны төсөв, санхүүгийн үйл явцыг мэдээллийн самбар болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, нээлттэй мэдээлсэн.

МУЕА-ын 2021.07.21-ний өдрийн 1754 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу ажиллагсдын зэрэг дэвийн нэмэгдлийн зөрүүг тооцож, 7 дугаар сарын цалин дээр олголоо.

ҮАГ-ын Тамгын даргаас ирүүлсэн 2021.07.19-ний өдрийн 4/1745, 2021.11.15-ны өдрийн 03/2435 дугаартай албан бичгийн дагуу ажиллагсдад 2021 оны эхний хагас жилийн болон 3 дугаар улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг олголоо.

ҮАГ-ын Тамгын даргын 2021.06.24-ний өдрийн А/26-ТГ дугаартай “Эд хөрөнгийн тооллого хийх тухай” тушаалын дагуу байгууллагын 2021 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг дарга, тэргүүлэх аудиторын 2021.06.25-ны өдрийн А/15, жилийн

эцсийн эд хөрөнгийн тооллогыг 2021.12.13-ны өдрийн А/27 дугаар дугаартай тушаалаар тус тус томилогдсон тооллогын комисс хийж гүйцэтгэлээ.

Тооллогын үр дүнгээр актлах эд хөрөнгийн саналыг өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцэн дүнг удирдлагад танилцуулж, ҮАГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст 2021.07.06-ны өдрийн 206 дугаартай албан бичгээр, 2019-2021 оны эхний хагас жилийн байдлаарх үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж, 2021.08.04-ний өдөр хүргүүлсэн.

ҮАГ-ын Өмч хамгаалах зөвлөлөөс байгууллагын 2021 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогын үр дүнгээр актлах хөрөнгө болон үндсэн хөрөнгийн данснаас бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэх хөрөнгийг тулгаж баталгаажуулах ажлыг 2021.12.10-ны өдөр зохион байгуулж, холбогдох тайланг хүргүүллээ.

Тооллогын үр дүнгээр албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг шинэчлэн хөтөлж, гарын үсгээр баталгаажууллаа. Хөрөнгө тус бүрийг кодын дагуу зурагжуулан зургийн цомогт баяжилт хийлээ.

Байгууллагын 2020 оны Төрийн өмч эзэмшүүлэх гэрээг баталгаажуулан цахим болон цаасаар 2021.10.01-ний өдөр СХОХ-т хүргүүллээ. 2020 оны төрийн өмчийн гэрээг 93 хувьтай дүгнүүллээ. Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй ААНБ-ын тооллогод хамрагдлаа.

Худалдан авах ажиллагаа зохион байгуулах босго үнээс давсан төсөв батлагдаагүй байна. Шууд худалдан авалтын хүрээнд шуудан үйлчилгээ, тээвэр шатахуун, бичиг хэргийн материалын худалдан авалтыг холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгэж байна. Цахимжуулалтын жилийн хүрээнд ҮАГ-аас хуваарилсан 20.0 сая төгрөгөөр байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авалтыг цаг алдалгүй хийж, материаллаг бааз суурийг сайжруулсан.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аудитын хуулийн этгээдэд олгох аудитын үйлчилгээний төлбөрт 15.9 сая төгрөг төвлөрснийг гэрээний дагуу гүйцэтгэгч байгууллагад шилжүүллээ.

Шилэн дансны улирлын тайланг хугацаанд нь илгээсэн ба 4 дүгээр улирлын байдлаар хуулийн хугацаанд оруулах 149 мэдээллийг сар бүр хугацаанд нь бүрэн байршуулж ажилласан. Хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Төсвийн тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийн дагуу 2021 оны батлагдсан төсвийн хуваарь болон сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг мэдээллийн самбарт цаасан хэлбэрээр байршуулж хэвшсэн бөгөөд тайлант хугацааны төсөв, санхүүгийн үйл явц ил тод, нээлттэй болсон байна.

НАЙМДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Дүгнэлт: 2021 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилт, 63 арга хэмжээ болон удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, нэмэлт ажил үүргийг 100% хэрэгжүүлэн ажиллалаа.

ҮАГ-т уламжлах санал, хүсэлт:

1. Орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагад тогтвор суурьшилтай, тасралтгүй ажиллаж байгаа ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, мөнгөн дэмжлэг үзүүлэх

2. Орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагын ажилтнуудыг улсын эмнэлэгт нарийн мэргэжлийн үзлэг, оношилгоонд хамруулах нөхцөл боломжийг бүрдүүлэх, төсөв санхүүгийн асуудлыг шийдвэрлэх
3. Бүсчилсэн болон танхимын дадлагажуулах сургалтыг зохион байгуулах